



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 10 өдөр

Дугаар 1/162

Хужирт сум

Газар эзэмших эрх шинээр олгох тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3. дахь заалт, Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай” 8/2/8 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Шивээт 4 дүгээр багийн нутаг Эрүүл мэндийн төвийн урд байрлах 224 м² үл хөдлөх эд хөрөнгийн доорх газрыг барилгын сууриас 3 м байхаар тооцон 354 м² газрыг суурь үнээр нь тус сумын 2 дугаар багийн иргэн Дагиймаагийн Цэвэлмаа (ИС78102001)-д Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор зориулалтаар 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших гэрээ байгуулан төлбөрийг улирал бүр тооцон хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

3. Захирамж гарсанаас хойш 90 хоногийн дотор байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, түүх археологийн судалгаа хийлгэхийг (Д.Цэвэлмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ